



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1/30

Хэрлэн сум

“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 18.8, Засгийн газрын 2016 оны "Олон улсын хүүхдийн спортын наадам зохион байгуулах тухай" 145 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Журам батлах тухай" 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн "“Өсвөрийн шигшээ баг”-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана." 1.4.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Өсвөр үеийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Дарга:	-Засаг даргын орлогч
Дэд дарга:	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд :	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга -Эрүүл мэндийн газрын ахлах мэргэжилтэн -Монголын Үндэсний Олимпын хорооны гишүүн -Санхүү, төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч -Биеийн тамир спортын газрын "Өсвөр үеийн шигшээ баг" хариуцсан ахлах дасгалжуулагч
Нарийн бичгийн дарга:	-Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, "Өсвөр үеийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 239